



ОНЦЛОХ МЭДЭЭ:

- Монгол Улсаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын үлдэгдэл буурч байхад гадаадаас Монголд оруулсан хөрөнгө оруулалтын үлдэгдэл нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын богино позиц нэмэгдэхэд нөлөөлжээ.
- Монгол Улсын нийт гадаад зээлийн үлдэгдэл 23.4 тэрбум ам.доллар байна.

Төлбөрийн тэнцэл

2016 оны 2-р улиралд урсгал данс 137 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 250 сая долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 8 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр буурчээ. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -121 сая ам.доллар байна.

2015 оны 2-р улиралтай харьцуулахад урсгал дансны алдагдал 100 сая ам.доллараар буурсан бол хөрөнгө ба санхүүгийн данс 144 сая ам.доллараар буурсан байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 1,275.3 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 4.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 3,591 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 29,510 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц 2016 оны 2-р улирлын байдлаар 25,919 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй буюу богино позицтой байна.

Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулах ба богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 7% буюу 1635 сая ам.доллараар өссөн.

Үүнд, багцын хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө оруулалтын богино позицууд 645 сая ам.доллар, 4301 сая ам.доллараар тус тус өсч, шууд хөрөнгө оруулалт болон гадаад валютын улсын нөөц 4098 сая ам.доллар, 31 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ.

Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц



АГУУЛГА


Төлбөрийн тэнцэл	2
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	4
Нийт гадаад зээл	6
Хавсралт	7

Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл тайлант улирлын эцэст 23,449 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8%-иар буюу 1,664 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын гадаад өр 26%-иар буюу 964 сая ам.доллараар өсч 4,706 сая ам.долларт,
- Төв банкны гадаад өглөг 5%-иар буюу 93 сая ам.доллараар буурч 1,758 сая ам.долларт,
- Банкуудын гадаад өр 3%-иар буюу 66 сая ам.доллараар өсч 2,167 сая ам.долларт,
- Бусад сектор (ААН)-ын гадаад өр 126%-иар буюу 4486 сая ам.доллараар өсч 8,060 сая ам.долларт,
- Гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эх үүсвэр 36%-иар буюу 3759 сая ам.доллараар буурч 6,758 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



Судалгаа, статистикийн газрын Статистикийн хэлтэс

Монголбанк
Бага тойруу 3,
Улаанбаатар 15160
Утас: 976-11-323243,
327088

Факс: +976-11-327088
Email:
bor@mongolbank.mn

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

УРСГАЛ ДАНС

2016 оны 2-р улиралд урсгал тэнцлийн алдагдал 137 сая ам.долларт хүрч, алдагдлын хэмжээ 2015 оны мөн үеэс 42%-иар буурчээ.

Өнгөрсөн оны мөн үед ашигтай гарч байсан бараа, үйлчилгээний худалдаа энэ улиралд 22 сая ам.долларын алдагдалтай гарахад барааны гадаад худалдааны ашиг 123 сая ам.доллараар өссөн хэдий ч үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 149 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 14%-иар буурч 1,982 сая ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд 376.6 сая ам.долларт хүрч, сүүлийн 10 улирал дараалан ашигтай гарлаа.

Барааны худалдааны тэнцэл сайжрахад тайлант улиралд нефтийн импорт 37%-иар, хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашины импорт 34%-иар буурсан нь голлон нөлөөлсөн. Харин өнгөрсөн он болон 2016 оны 1 дүгээр улиралд бууралттай байсан хэрэглээний барааны импорт тайлант хугацаанд 4%-иар өссөн байна.

Үйлчилгээний худалдаа

Тайлант улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны 2-р улирлын гүйцэтгэлээс 60%-иар өсч 399 сая ам. долларт хүрсэн байна.

Алдагдал ийнхүү өсөхөд бусад үйлчилгээний зардал 149%-иар буюу 181 сая ам.доллараар өссөн нь голчлон нөлөөлжээ. Бусад үйлчилгээний зардал өсөхөд санхүүгийн, тээврийн хэрэгслийн түрээсийн, архитектур, инженер болон техникийн үйлчилгээний өсөлт голчлон нөлөөлжээ.

Орлого

2016 оны 2-р улирлын гүйцэтгэлээр орлогын данс 182 сая ам.долларын алдагдалтай гарч 2015 оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 41%-иар буюу 124 сая ам.доллараар буурсан. Тайлант хугацааны голлох төлбөрийг дурьдвал:

- ААНБ-ууд гадаадын хөрөнгө оруулагчдад 34 сая ам.долларын ноогдол ашгийг хуваарилж, хөрөнгө оруулагчдын зээлийн үүсвэрт 117 сая ам.долларын хүү төлсөн,
- Монгол Улсын Засгийн газар бонд, гадаад зээлийн эх үүсвэрт 36 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- ААНБ-ууд бусад гадаад зээлийн эх үүсвэрт 18 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Банкууд гадаад зээл болон харьяат бусын харилцах, хадгаламжийн дансанд 30 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Төр, хувийн хэвшил хамтдаа бондын эх үүсвэрт 23 сая долларын хүүгийн төлбөрийг төлсөн байна.


Урсгал шилжүүлэг

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 24%-иар өссөн, гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 26.4%-иар буурснаар ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 31 сая ам.доллар болж өссөн байна.


Хүснэгт 1. Урсгал тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	II улирал		өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
I. Урсгал тэнцэл	-237	-137	100	42%
A. Бараа, үйлчилгээний худалдаа	4	-22	-27	-616%
а. Бараа	254	377	123	48%
б. Үйлчилгээ	-250	-399	-149	-60%
B. Цэвэр орлого	-306	-182	124	41%
B. Урсгал шилжүүлэг	65	67	2	3%

Дүрслэл 4. Барааны худалдаа



Дүрслэл 5. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	20,001	38% ▲	28%	1,700	8% ▼	-12%
Америк	7,597	14% ▼	-7%	4,233	19% ▼	-8%
Хятад	2,953	6% ▼	-13%	3,084	14% ▼	-48%
Гонг Конг	1,088	2% ▼	-44%	933	4% ▼	-51%
Англи	1,083	2% ▼	-66%	1,180	5% ▲	40%
ОХУ	787	1% ▼	-42%	2,577	12% ▲	3%
Сингапур	776	1% ▼	-45%	89	0% ▼	-92%
Швейцарь	-	0% ▼	-100%	55	0% ▼	-97%
Герман	1,672	3% ▼	-32%	582	3% ▼	-48%
Япон	1,744	3% ▲	9%	547	2% ▼	-17%
Бусад	15,482	29% ▲	1%	7,173	32% ▼	0%
НИЙТ	53,183	100%		22,152	100%	

Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (жилээр, сая ам.доллар)

	II улирал			Өөрчлөлт	
	2014	2015	2016	Мөнгөн дүн	Хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	12.0	25.1	31.0	6.0	23.8%
Гаднаас орж ирсэн	51.9	55.2	53.2	-2.0	-3.6%
Гадагш шилжүүлсэн	-39.8	-30.1	-22.2	7.97	-26.4%

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 250 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 144 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Энэ нь Монгол Улсад орох багцын хөрөнгө оруулалтын санхүүжилт цэвэр дүнгээрээ өнгөрсөн оны мөн үеэс 157 сая ам.доллараар буурсанаар тайлбарлагдаж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2016 оны 2-р улиралд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр -4,512.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 4,597.4 сая ам.доллараар буурсан байна.

Үүнд, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн санхүүжилт өнгөрсөн оны түвшнээс 4,081.3 сая ам.доллараар буурч, -4,110.8 сая ам.долларт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл, Австрали улсаас манай улсад оруулсан хөрөнгө оруулалт 2015 онд -36.5 сая ам.доллар буюу хөрөнгө оруулалтаа буцаан татсан үзүүлэлттэй байсан бол 2016 онд өмнөх оны мөн үеэс 4,141 сая ам.доллараар буурч -4,177.1 сая ам.долларт, ОХУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 2015 онд 2.3 сая ам.доллар байсан бол 2016 онд хөрөнгө оруулалтаа буцаан татсантай холбоотойгоор 395 сая ам.доллараар буурч -392.6 сая ам.долларт хүрсэн бол Франц улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 4.3 сая ам.доллараар өсч 4.4 сая ам.долларт, Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 13 сая ам.доллараар өсч 12.6 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Эдийн засгийн салбараар нь авч үзвэл 2016 оны 2 дугаар улирлын байдлаар нийт хөрөнгө оруулалтын бууралтын 95%-ыг буюу -4,277,5 сая ам.долларыг уул уурхайн салбарт оруулсан хөрөнгө оруулалт, 9% буюу 403,9 сая ам.долларыг боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалтууд тус тус эзэлж байгаа бөгөөд энэ нь зарим томоохон аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эргэн төлөлт болон дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалтын өөрчлөлт зэргээс шалтгаалж байна.

Эдийн засгийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 4207 сая ам.доллар, боловсруулах үйлдвэр 408 сая ам.доллар, цахилгаан, хий, уур, агааржуулалт 28 сая ам.доллараар тус тус буурсан бол үл хөдлөх хөрөнгө 49 сая ам.доллар, үйлчилгээний бусад салбар 24 сая ам.доллар, санхүүгийн болон даатгалын салбар 6 сая ам.доллар, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 4 сая ам.доллараар тус тус өссөн байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант хугацаанд 485,3 сая ам.долларын ашигтай гарчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 157 сая ам.доллараар буурсан үзүүлэлт байна.

Бусад хөрөнгө оруулалт

Тайлант онд бусад хөрөнгө оруулалтын данс 4,252.1 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал тэнцэл 4,614.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	II улирал		өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл	394	250	-144	37%
<i>A. Хөрөнгийн данс</i>	<i>30</i>	<i>26</i>	<i>-4</i>	<i>-13%</i>
<i>B. Санхүүгийн данс</i>	<i>364</i>	<i>224</i>	<i>-140</i>	<i>-38%</i>
<i>а. Шууд хөрөнгө оруулалт</i>	<i>85</i>	<i>-4,513</i>	<i>-4,597</i>	<i>5438%</i>
<i>Гадагш хийсэн</i>	<i>-3</i>	<i>-2</i>	<i>1</i>	<i>-35%</i>
<i>Монгол Улсад орсон</i>	<i>87</i>	<i>-4,511</i>	<i>-4,598</i>	<i>5276%</i>
<i>б. Багцын хөрөнгө оруулалт</i>	<i>642</i>	<i>485</i>	<i>-157</i>	<i>24%</i>
<i>в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</i>	<i>0</i>	<i>0</i>	<i>0</i>	<i>-616%</i>
<i>г. Бусад хөрөнгө оруулалт</i>	<i>-362</i>	<i>4,252</i>	<i>4,615</i>	<i>-1273%</i>
<i>Үүнээс: Худалдааны зээл</i>	<i>-44</i>	<i>54</i>	<i>98</i>	<i>222%</i>
<i>Бэлэн мөнгө харилцах</i>	<i>205</i>	<i>-315</i>	<i>-520</i>	<i>-3</i>

Хүснэгт 5. ГШХО, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	II улирал		2016.II/15.II	
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	Австрали	-4177.1	93%	-4141.3	▼
2	Америк	14.5	0%	-2.4	▼
3	Англи	3.2	0%	33.5	▲
4	Арабын Емират	4.9	0%	-5.7	▼
5	Герман	19.5	0%	23.0	▲
6	Голланд	-76.8	2%	-96.6	▼
7	Гонг-Конг	71.2	-2%	-8.1	▼
8	Канад	12.6	0%	13.3	▲
9	ОХУ	-392.6	9%	-394.8	▼
10	Сингапур	-8.9	0%	-11.3	▼
11	Солонгос (өмнөд)	-7.0	0%	-13.6	▼
12	Финлянд	3.6	0%	-1.2	▼
13	Франц	4.4	0%	4.3	▲
14	Япон	13.7	0%	0.9	▲
15	Бусад	1.8	0%	0.1	▲
Нийт		-4511.1	100%		

Дүрслэл 6. ГШХО, ЭЗ-ийн салбараар (сая ам.доллар)

Эдийн засгийн салбар	2015.II	2016.II	2016.II/15.II	
			Өөрчлөлт	
1 Барилга	16.5	9.7	-6.8	▼
2 Боловсрол	0.3	1.3	1.0	▲
3 Боловсруулах үйлдвэрлэл	3.7	-403.9	-407.6	▼
4 Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	76.8	69.6	-7.2	▼
5 Мэдээлэл, холбоо	3.7	-8.5	-12.1	▼
6 Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	17.2	10.6	-6.6	▼
7 Санхүүгийн болон даатгалын үйл	14.8	20.4	5.6	▲
8 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.7	5.0	4.3	▲
9 Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	10.6	1.0	-9.6	▼
10 Уул уурхай, олборлолт	-70.9	-4277.5	-4206.6	▼
11 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.8	24.8	23.9	▲
12 Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	8.1	56.7	48.6	▲
13 Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.3	-26.7	-28.0	▼
14 Бусад	3.6	6.4	2.8	▲
Нийт	87.2	-4511.1	-4598	▼

Алдаа ба орхигдуулга

Тайлант хугацаанд алдаа ба орхигдуулга үзүүлэлт -121 сая ам.доллар гарсан байна.

Уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд гадагш чиглэсэн хөрөнгийн урсгалын төлбөр тооцоо дутуу бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2016 оны 2-р улирлын эцэст -25,919.0 сая ам.доллар байв. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 25.9 тэрбум ам.доллараар их байна

Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,591.4 сая ам.доллар байна. Үүний 46%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 36%-ийг гадаад валютын албан нөөц, 11%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 7%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад Гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 29,510.5 сая ам.долларт хүрчээ. Үүний 43%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 45%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 12%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 47%-ийг буюу 5,969.0 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 53% буюу 6,757.6 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх улирлаас 3%-иар буюу 815.6 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 0.9%-иар буюу 30.5 сая ам.доллараар, гадаад пассив 3.0%-иар буюу 846.1 сая ам.доллараар өссөнөөр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 25%-иар буюу 4,098.4 сая ам.доллараар буурснаар, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 24%-иар буюу 645.0 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 60%-иар буюу 4,300.6 сая ам.доллараар тус тус өссөнөөр,
- Өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц төлбөрийн тэнцлийн орох, гарах урсгалаар 232.5 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр -137.8 сая ам.доллараар, бусад өөрчлөлтөөр -594.9 сая ам.доллараар, ханшийн зөрүүгээр 149.6 сая ам.доллараар өөрчлөгдсөнөөр тайлбарлаж байна.

2012 оны эцсээс эхлэн гадаад активын дүн буурч байгаа нь гадаад валютын улсын нөөцийн бууралтаас шалтгаалсан бол гадаад пассив өсөлт нь бусад хөрөнгө оруулалтын тодруулбал ААН-үүд болон Хөгжлийн банкны гадаад зээлийн эх үүсвэрийн өсөлтөөр голчлон тайлбарлагдаж байна.


Гадаад секторын статистик

Гадаад секторын статистик гэж аливаа улс орны гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг үзүүлэгч эдийн засгийн төлбөр тооцооны дансдын урсгал болон үлдэгдлийн мөнгөн үзүүлэлтийг хэлдэг. Энэхүү үзүүлэлтэд төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээл, гадаад валютын улсын нөөцийн мэдээ зэрэг статистик мэдээллүүд багтдаг.


Хүснэгт 6. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	6/30/2015	6/30/2016	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-24,284	-25,919	1,635	7%
I. Гадаад актив	3,660	3,591	-68	-2%
1. Шууд хөрөнгө оруулалт	375	381	6	2%
2. Багцын хөрөнгө оруулалт	315	254	-62	-20%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	2	9	6	264%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,281	1,651	371	29%
5. Нөөц актив	1,686	1,297	-389	-23%
II. Гадаад пассив	27,944	29,510	1,567	6%
1. Шууд хөрөнгө оруулалт	16,575	12,727	-3,849	-23%
2. Багцын хөрөнгө оруулалт	3,590	3,634	44	1%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	6	13	7	135%
4. Бусад хөрөнгө оруулалт	7,773	13,137	5,364	69%

Дүрслэл 7. Гадаад актив



Дүрслэл 8. Гадаад пассив



Дүрслэл 9. Статистик хамаарал

		Төлбөрийн тэнцэл (BOP)	
		Урсгал ба хөрөнгийн данс	
Гадаад хөрөнгө оруулалтын позиц (IIP)	IIP (Хугацааны эхэнд)	Санхүүгийн данс	Дахин үнэлгээ /Үнэ, ханш, бусад/
			IIP (Хугацааны эцэст)
		Алдаа ба оржигдуулга	

Багцын хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад актив 2016 оны 2-р улирлын эцэст 253.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 20%-иар буурсан бол гадаад пассивын үлдэгдэл 3,634.1 сая ам.долларт хүрч 1%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Актив: эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл, Гонг конг 62%, Австрали 12%, АНУ 8%, Сингапур 6%, Канад 4%, БНХАУ 3%, Их Британи 2%, Швейцарь 1%, Солонгос 1%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал, Сингапур улс 21%, Гонг конг 14%, Япон улс 5%, АНУ 2%, БНХАУ 2%, бусад улс 13%, үлдсэн 43% нь эзэмшигч тодорхойгүй буюу хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа тул аль улсын эдийн засгийн харьяат эзэмшиж буйг тодорхойлох боломжгүй байна.

Компаниудын хувьцааны үнэ

Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны үнэ 2016 оны 2-р улиралд өмнөх жилийн мөн үеийн хаалтын ханштай харьцуулахад дунджаар 48%-иар буурчээ. Тодруулбал,

Өссөн: Сентерра гоулд компанийн хувьцааны үнэ 7%-иар өсч 7.7 канад долларт хүрсэн.

Буурсан: Харанга ресурс компанийн хувьцааны үнэ 85%-иар, Саусови ресурс 72%-иар, Монголиа Майнинг корпорацийн хувьцааны үнэ 71%-иар, Петро матад 61%-иар, Писс мап холдинг 59%-иар, Монголиан энеджи корпорацийн үнэ 56%-иар, Пропеси кол 48%-иар, Винсвэй Кокинг кол 20%-иар буюу түүхий эд олборлогч компаниудын хувьцааны үнэ их хэмжээгээр, үнэт металл орлоглогч компаниудын хувьцааны үнэ харьцангуй бага хувиар буурсан байна.


Засгийн газрын бондын үнэ

2016 оны 2 дугаар сард бүтээгдэхүүн түүхий эдийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар буурч үүнтэй уялдан Засгийн газрын 5 жилийн хугацаатай бондын үнэ 7.4 хувь, 10 жилийн хугацаатай гаргасан бондын үнэ 16.2 хувиар тус тус буурсан. Харин 2016 оны 3 дугаар сараас түүхий эдийн үнэ бага зэрэг тогтворжиж, гадаад зах зээлд үүссэн тодорхой бус байдал арилахад Засгийн газрын бондын үнэ ялимгүй өссөөр 2016 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар өмнөх оны мөн үеэс Засгийн газрын 5 жилийн хугацаатай гаргасан бондын үнэ 3.9 хувиар, 10 жилийн хугацаатай гаргасан бондын үнэ 6.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Бондын өгөөжийн муруйгаас дээрх хамаарлыг харж болно. Тухайлбал, Засгийн газрын 5 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 2016 оны 2 сард хамгийн ихдээ 13.3 хувь, 10 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 11.9 хувь, Дим Сам бондын өгөөж 2016 оны 3 дугаар сард 16.6 хувьд тус тус хүрч байсан / эрсдэл өссөнийг илэрхийлнэ/ бол 2016 оны дугаар улирлын байдлаар харгалзан 5.8 хувь, 8.7 хувь, 10.6 хувь болж буураад байна.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын позицыг тооцоолохдоо 2015 оны 3 дугаар улирлаас эхлэн Засгийн газрын бондуудыг зах зээлийн үнэлгээгээр тооцоолон тайлант хугацаан дахь үлдэгдлийг гаргаж байна. 2016 оны 2 дугаар улирлын байдлаар Засгийн газрын 5 жилийн хугацаатай гаргасан бондын үнэлгээ 470.5 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай гаргасан бондын үнэлгээ 828.4 сая ам.доллар, Дим Сам бондын үнэлгээ 150.5 сая ам.доллар байна.

Хүснэгт 7. Багцын ХО-ын позиц, сая ам.доллар




Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ

№	Компаний нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					6/30/2015	6/30/2016	
1	Turquoise Hill Resources	TRQ.US	US	USD	3.79	3.38	-11% ▼
2	Mongolian Mining Corp	0975.HK	HK	HKD	0.32	0.09	-71% ▼
3	Centerra Gold	CG.TO	CAD	CAD	7.20	7.70	7% ▲
4	Southgobi Resources	1878.HK	HK	HKD	4.96	1.41	-72% ▼
5	Winsway Coking Coal	1733.HK	HK	HKD	0.30	0.24	-20% ▼
6	Mongolia Energy Corp	0276.HK	HK	HKD	0.39	0.17	-56% ▼
7	Petro Matad	MAT.DL	LN	GBP	4.13	1.63	-61% ▼
8	Prophecy Coal Corp	PCY.TO	CAD	CAD	0.05	0.03	-48% ▼
9	Haranga resources	HAR.AX	AU	AUD	0.02	0.00	-85% ▼
10	Peace Map Holding Limited	0402.HK	HK	HKD	0.37	0.15	-59% ▼

Дүрслэл 10. ЗГ-н бондын үнэ, Түүхий эдийн үнийн индекс



Дүрслэл 11. МУ-н ЗГ-н бондуудын өгөөжийн муруй



IV. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2016 оны 2-р улирлын байдлаар 23,449 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1,664 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 964 сая ам.доллараар нэмэгдэж 4,706 сая ам.долларт хүрсэн бол Монголбанкны гадаад өр 93 сая ам.доллараар буурч 1,758 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2016 оны 2 дугаар улирлын эцэст 2,167 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3%-иар буюу 66 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 41%-ийг урт хугацаат зээл, 32%-ийг бонд, өрийн бичиг, 18%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 9%-ийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкууд тайлант улиралд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 105.1 сая ам.долларын урт хугацаат, 79.5 сая ам.долларын богино хугацаат зээлийг шинээр авч, гэрээний дагуу 92.8 сая ам.долларын урт, 77.5 сая ам.долларын богино хугацаат зээлийг буцаан төлснөөр зээлийн үлдэгдэл харгалзан 1,779 сая ам.доллар, 389 сая ам.долларт тус тус хүрчээ.

Банкны бус салбар

Банк бус салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2016 оны 2-р улирлын эцэст 14,818 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 727 сая ам.доллараар өссөн.

Салбарын нийт зээлийн 46% буюу 6,758 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна. Эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай.

Хөрөнгө оруулагчдын санхүүжилтийн ашиглалт болон буцаан төлөлтийн байдлыг авч үзвэл тайлант онд харгалзан 190 сая ам.доллар, 4,301 сая ам.доллар байжээ.


ААН-үүдийн экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 539 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	6/30/2015	6/30/2016	өөрчлөлт		* %2
			дүн	хувь	
Нийт гадаад өр	21,785	23,449	1,664	8%	100%
I. Засгийн газар	3,741	4,706	964	26%	20%
II. Төв банк	1,851	1,758	-93	-5%	7%
III. Банк	2,102	2,167	66	3%	9%
Богино хугацаат	277	389	112	40%	2%
Урт хугацаат	1,825	1,779	-46	-3%	8%
IV. Бусад сектор	3,574	8,060	4,486	126%	34%
Богино хугацаат	453	463	9	2%	2%
Урт хугацаат	3,121	7,598	4,477	143%	32%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	10,517	6,758	-3,759	-36%	29%

*: Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр

Дүрслэл 12. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 13. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	2 дугаар улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2014	2015	2016	Дүн	2015/14	Дүн	2016/15
I. Урсгал Тэнцэл	-602	-237	-137	365	-61%	100	-42%
A. Бараа ба үйлчилгээний худалдаа	-401	4	-22	405	-101%	-27	-616%
1. Бараа	6	254	377	248	40x	123	48%
1.1 Ерөнхий эд бараа	14	200	214	185	14x	15	7%
Экспорт Ф.О.Б. (Кредит)	1,494	1,221	1,010	-273	-18%	-210	-17%
Үүнээс: Зэсийн баяжмал	637	635	435	-2	0%	-200	-31%
Импорт Ф.О.Б. (Дебит)	-1,480	-1,021	-796	459	-31%	225	-22%
Үүнээс: Нефтийн	-298	-171	-105	126	-42%	66	-39%
Хүнсний	-134	-108	-117	26	-19%	-8	8%
1.2 Мөнгөжөөгүй алт	0	60	169	60	-	109	182%
Кредит	0	60	169	60	-	109	182%
Дебит	0	0	0	0	0%	0	0%
1.3 Бусад	-8	-5	-7	3	-32%	-1	21%
Кредит	1	0	0	-1	-100%	0	0%
Дебит	-9	-5	-7	3	-38%	-1	21%
2. Үйлчилгээ	-407	-250	-399	157	-39%	-149	60%
2.1 Тээвэр	-145	-77	-55	68	-47%	22	-28%
Кредит	51	68	76	17	33%	7	11%
Дебит	-197	-145	-131	51	-26%	14	-10%
2.2 Аялал	-79	-52	-41	27	-34%	11	-20%
Кредит	38	57	68	19	51%	11	19%
Дебит	-117	-109	-109	8	-7%	0	0%
2.3 Бусад үйлчилгээ	-183	-121	-303	62	-34%	-181	149%
Кредит	57	63	65	6	10%	3	4%
Дебит	-240	-184	-368	56	-23%	-184	100%
B. Орлого	-251	-306	-181.7	-55	22%	124	-41%
1. Ажиллагсдын цалин хөлс	-21	-11	-5	10	-46%	7	-60%
Кредит	13	13	15	0	-3%	2	14%
Дебит	-35	-24	-19	10	-30%	5	-21%
2. Хөрөнгө оруулалтын орлого	-230	-295	-177	-65	28%	117	-40%
Кредит	1	1	2	0	-22%	1	96%
Дебит	-231	-296	-179	-64	28%	116	-39%
C. Урсгал шилжүүлэг (цэвэр)	50	65	67	14	29%	2	3%
Кредит	94	99	95	5	5%	-4	-4%
Дебит	-44	-34	-28	10	-23%	6	-17%
Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга	12	25	31	13	108%	6	24%
Кредит	52	55	53	3	6%	-2	-4%
Дебит	-40	-30	-22	10	-24%	8	-26%
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	-217	394	250	610	-282%	-144	-37%
A. Хөрөнгийн данс	25	30	26	5	20%	-4	-13%
Кредит	25	30	26	5	19%	-4	-12%
Дебит	0	0	0	0	-50%	0	207%
B. Санхүүгийн данс	-241	364	224	606	-251%	-140	-38%
1. Шууд хөрөнгө оруулалт	84	85	-4,513	1	1%	-4,597	55x
1.1 Гадагш хийсэн	-10	-3	-2	8	-75%	1	-35%
1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	-9	-1	-1	8	-85%	0	-2%
1.1.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	0	0	0	0	0%	0	0%
1.1.3 Бусад хөрөнгө	-1	-1	0	0	0%	1	0%
1.2 Монголд орсон	94	87	-4,511	-7	-8%	-4,598	53x
1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	80	97	-312	17	21%	-408	-423%
1.2.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт	-51	20	-89	71	-139%	-109	-542%
1.2.3 Бусад хөрөнгө	66	-30	-4,111	-95	-145%	-4,081	139x
2. Багцын хөрөнгө оруулалт	3	642	485	639	224x	-157	-24%
2.1 Актив	-9	-16	0	-7	78%	16	-98%
2.1.1 Хөрөнгийн хувьцаа	-7	-22	-1	-14	188%	21	-97%
2.1.2 Өрийн бичиг	-1	6	0	7	-477%	-5	-95%
2.1.2.1 Бонд, үнэт цаас	-1	0	0	1	-99%	0	-85%
2.1.2.2 Мөнгөний захын	0	6	0	6	130x	-5	-95%
2.2 Пассив	12	658	486	646	56x	-173	-26%
2.2.1 Хөрөнгийн хувьцаа	6	2	4	-3	-60%	2	73%
2.2.2 Өрийн бичиг	6	656	482	650	619x	-174	-27%
2.2.2.1 Бонд, үнэт цаас	6	656	482	650	104x	-174	-27%
2.2.2.2 Мөнгөний захын	0	0	0	0	0%	0	0%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (цэвэр)	0	0	0	0	0%	0	0%
3.1 Актив	0	-1	4	-2	0%	5	0%
3.2 Пассив	-1	1	-5	2	0%	-6	0%
4. Бусад хөрөнгө оруулалт	-328	-362	4,252	-35	11%	4,615	14x
4.1 Актив	-243	-405	-48	-162	67%	357	-88%
4.1.1 Худалдааны зээл	-69	-76	-10	-6	9%	66	-87%
4.1.2 Зээл	-1	-1	-1	1	-48%	0	-30%
4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах	-172	-328	-38	-156	91%	290	-89%
4.1.4 Бусад актив	0	0	0	0	0%	0	0%
4.2 Пассив	-85	42	4,300	127	-150%	4,258	102x
4.2.1 Худалдааны зээл	-18	32	63	50	-273%	32	100%
4.2.2 Зээл	-53	-11	4,566	42	-80%	4,576	430x
4.2.2.1 Төв банк	0	0	0	0	0%	0	0%
4.2.2.2 Засгийн газар	5	-1	119	-6	-120%	120	110x
4.2.2.3 Банк	-1	-12	61	-11	11x	72	-613%
4.2.2.4 Бусад сектор	-57	2	4,386	59	-104%	4,384	1970x
4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах	-14	45	-277	59	-425%	-322	-716%
4.2.4 Бусад пассив	0	-24	-52	-24	0%	-28	0%
III. Алдаа болон орхигдуулга	211	197	-121	-14	-7%	-318	-161%
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	<i>-607</i>	<i>354</i>	<i>-8</i>	<i>962</i>	<i>-363</i>	<i>-363</i>	<i>-102%</i>
IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт*	607	-354	8	-962	-158%	363	-102%
1. Актив	631	-354	8	-985	-156%	363	-102%
1.1 Мөнгөжсөн алт	0	0	0	0	0%	0	0%
1.2 Зээлжих тусгай эрх	0	0	0	0	0%	0	42%
1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө	0	0	0	0	0	0	0
1.4 Бэлэн валют ба харилцах	631	-354	8	-985	-156%	363	-102%
1.5 Бусад нөөц актив	0	0	0	0	0%	0	0%
2. Пассив	-24	0	0	24	-100%	0	0%
2.1 ОУВС-ийн зээл	-24	0	0	24	-100%	0	0%
2.2 Онцгой санхүүжилт	0	0	0	0	0%	0	0%

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

Эх сурвалж: Монголбанк

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016	6/30/2016
Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)	-14,219	-20,440	-23,689	-24,066	-24,284	-24,488	-24,701	-25,103	-25,919
I. Гадаад актив	6,380	4,005	3,437	2,999	3,660	3,240	3,230	3,561	3,591
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	1,191	258	355	367	375	376	382	378	381
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	1,191	252	348	360	366	364	369	365	368
1.1.1 Салбар компаниас авах	1,191	252	348	360	366	364	369	365	368
1.1.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0	0	0
1.2 Бусад хөрөнгө	1	6	7	7	10	12	13	13	13
1.2.1 Салбар компаниас авах	1	6	7	7	10	12	13	13	13
1.2.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0	0	0
2. Багцын хөрөнгө оруулалт	106	387	280	288	315	251	235	239	254
2.1 Хөрөнгийн хувьцаа	101	379	205	213	246	218	202	206	220
2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
2.1.3 Банкууд	0	0	0	0	3	3	3	3	3
2.1.4 Бусад салбар	101	379	205	213	243	215	199	203	218
2.2 Өрийн бичиг	5	9	75	76	70	33	33	33	33
2.2.1 Бонд, үнэт цаас	0	0	52	52	52	15	15	15	15
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.3 Банкууд	0	0	0	0	0	1	1	1	1
2.2.1.4 Бусад салбар	0	0	52	52	52	14	15	15	15
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	4	8	24	24	18	18	18	18	18
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	4	8	24	24	18	18	18	18	18
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	0	9	1	2	13	8	13	9
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	0	9	1	2	13	8	13	9
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0
4. Бусад хөрөнгө оруулалт	957	1,112	1,144	1,019	1,281	1,188	1,283	1,665	1,651
4.1 Худалдааны зээллэг	384	540	566	535	611	516	607	666	676
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	384	540	566	535	611	516	607	666	676
Урт хугацааны	54	5	4	4	5	4	4	4	5
Богино хугацааны	329	534	562	531	606	512	603	662	671
4.2 Зээл	15	5	51	51	52	53	52	64	64
4.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	15	2	49	50	50	51	51	63	63
Урт хугацааны	0	0	45	45	46	46	47	47	48
Богино хугацааны	15	2	4	4	4	4	4	16	16
4.2.4 Бусад салбар	0	3	2	2	2	2	1	1	1
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	3	2	2	2	2	1	1	1
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	558	567	527	433	618	619	623	935	911
4.3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	530	494	315	299	430	474	441	613	587
4.3.4 Бусад салбар	29	73	212	134	188	146	182	323	325
4.4 Бусад актив	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
5. Нөөц актив	4,126	2,248	1,650	1,324	1,686	1,413	1,323	1,265	1,297

Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016	6/30/2016
II. Гадаад пассив	20,599	24,445	27,127	27,066	27,944	27,728	27,931	28,664	29,510
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	13,458	15,729	16,693	16,517	16,575	16,512	16,680	16,822	12,727
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	5,101	5,388	6,078	5,989	6,059	6,040	6,004	5,972	5,969
1.1.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0	0	0
1.1.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	5,101	5,388	6,078	5,989	6,059	6,040	6,004	5,972	5,969
1.2 Бусад хөрөнгө	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850	6,758
1.2.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0	0	0
1.2.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850	6,758
2. Багцын хөрөнгө оруулалт	2,689	2,470	2,913	2,906	3,590	3,043	2,961	2,975	3,634
2.1 Хөрөнгийн хувьцаа	113	35	94	87	94	82	84	76	79
2.1.1 Банкууд	0	0	11	11	11	11	11	11	11
2.1.2 Бусад салбар	113	35	83	76	83	71	73	65	68
2.2 Өрийн бичиг	2,576	2,435	2,819	2,819	3,496	2,961	2,877	2,899	3,555
2.2.1 Бонд, үнэт цаас	2,576	2,435	2,819	2,819	3,494	2,959	2,875	2,897	3,553
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	2,080	2,080	1,500	1,500	1,685	1,460	1,418	1,395	1,964
2.2.1.3 Банкууд	495	351	473	472	959	668	649	643	692
2.2.1.4 Бусад салбар	1	4	847	847	851	831	808	859	897
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	0	0	0	0	2	2	2	2	2
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	0	0	0	0	2	2	2	2	2
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	0	12	4	6	16	13	18	13
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	0	12	4	6	16	13	18	13
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0
4. Бусад хөрөнгө оруулалт	4,452	6,246	7,508	7,639	7,773	8,157	8,277	8,850	13,137
4.1 Худалдааны зээллэг	252	511	594	438	538	455	470	476	539
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	252	511	594	438	538	455	470	476	539
Урт хугацааны	31	339	291	212	358	282	302	307	368
Богино хугацааны	221	173	303	226	180	173	167	168	171
4.2 Зээл	3,621	4,427	5,165	5,187	5,199	5,308	5,626	6,021	10,606
4.2.1 Төв банк	78	75	71	68	69	68	68	68	68
ОУВС-гийн зээл	78	75	71	68	69	68	68	68	68
Бусад урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	2,184	2,184	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641	2,742
Урт хугацааны	2,184	2,184	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641	2,742
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	337	629	904	902	890	936	1,106	1,080	1,173
Урт хугацааны	279	429	589	611	613	713	775	727	785
Богино хугацааны	58	200	315	290	277	223	331	353	389
4.2.4 Бусад салбар	1,023	1,538	2,081	2,162	2,183	2,222	2,221	2,232	6,622
Урт хугацааны	735	1,305	1,822	1,901	1,912	1,976	1,982	1,994	6,333
Богино хугацааны	288	233	259	261	271	246	239	237	290
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	142	160	1,589	1,877	1,921	2,183	1,954	2,157	1,848
4.3.1 Төв банк	0	0	1,449	1,773	1,771	2,043	1,772	1,928	1,654
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	142	160	140	104	151	140	182	229	193
4.3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0
4.4 Бусад пассив	436	1,147	160	138	114	212	228	196	144
4.4.1 Төв банк	336	990	48	36	12	100	120	88	36
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	336	990	48	36	12	100	120	88	36
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	100	157	112	102	102	112	108	108	108
Урт хугацааны	100	157	112	102	102	112	108	108	108
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0

Эх сурвалж: Монголбанк

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2012	3/31/2013	2013.Q2	9/30/2013	12/31/2013	3/31/2014	6/30/2014	9/30/2014	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016	6/30/2016
1. Засгийн газар	3,684	3,568	3,632	3,657	3,684	3,688	3,672	3,596	3,610	3,556	3,741	3,542	3,648	4,036	4,706
1.1 Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Харилцах, хадгаламж 5/															
Өрийн бичиг 4/															
Зээл															
Худалдааны зээл болон урьдчилгаа															
Бусад өглөг 6/															
1.2 Урт хугацаат	3,684	3,568	3,632	3,657	3,684	3,688	3,672	3,596	3,610	3,556	3,741	3,542	3,648	4,036	4,706
Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/															
Харилцах, хадгаламж 5/															
Өрийн бичиг 4/	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,500	1,685	1,460	1,418	1,395	1,964
Зээл	2,184	2,068	2,132	2,157	2,184	2,188	2,172	2,096	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641	2,742
Худалдааны зээл болон урьдчилгаа															
Бусад өглөг 6/															
2. Төвбанк	415	396	481	892	1,065	1,042	1,040	1,435	1,568	1,876	1,851	2,211	1,960	2,084	1,758
2.1 Богино хугацаат	337	322	407	817	990	967	965	1,362	1,497	1,809	1,783	2,143	1,892	2,016	1,690
Харилцах, хадгаламж 5/	337	322	407	817	990	967	965	1,302	1,449	1,773	1,771	2,043	1,772	1,928	1,654
Өрийн бичиг 4/															
Зээл															
Худалдааны зээл болон урьдчилгаа								60	48	36	12	100	120	88	36
Бусад өглөг 6/															
2.2 Урт хугацаат	78	74	75	75	75	75	75	73	71	68	69	68	68	68	68
Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/	75	73	73	75	75	75	75	73	71	68	69	68	68	68	68
Харилцах, хадгаламж 5/															
Өрийн бичиг 4/															
Зээл	3	1	1	0	0	0	0	0	0						
Худалдааны зээл болон урьдчилгаа															
Бусад өглөг 6/															
3. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1,074	1,131	1,213	1,233	1,298	1,453	1,459	1,513	1,629	1,579	2,102	1,856	2,045	2,061	2,167
3.1 Богино хугацаат	58	59	61	82	200	198	215	258	315	290	277	223	331	353	389
Харилцах, хадгаламж 5/															
Өрийн бичиг 4/															
Зээл	58	59	61	82	200	198	215	258	315	290	277	223	331	353	389
Худалдааны зээл болон урьдчилгаа															
Бусад өглөг 6/															
3.2 Урт хугацаат	1,016	1,072	1,152	1,151	1,098	1,254	1,244	1,255	1,314	1,289	1,825	1,633	1,714	1,707	1,779
Харилцах, хадгаламж 5/	142	173	203	169	160	153	136	143	140	104	151	140	182	229	193
Өрийн бичиг 4/	495	501	484	478	351	462	463	461	473	472	959	668	649	643	692
Зээл	379	398	465	504	586	639	645	651	701	713	715	825	883	835	893
Худалдааны зээл болон урьдчилгаа															
Бусад өглөг 6/															
4. Бусад салбарууд	1,856	2,214	2,237	2,469	2,633	3,094	3,041	3,582	3,522	3,446	3,574	3,510	3,501	3,568	8,060
4.1 Богино хугацаат	508	552	457	469	406	455	457	551	562	486	453	421	409	408	463
Харилцах, хадгаламж 5/															
Өрийн бичиг 4/											2	2	2	2	2
Зээл	288	296	280	277	233	225	240	275	259	261	271	246	239	237	290
Худалдааны зээл болон урьдчилгаа	221	256	178	192	173	229	217	276	303	226	180	173	167	168	171
Бусад өглөг 6/															
4.2 Урт хугацаат	1,348	1,662	1,780	2,000	2,228	2,640	2,584	3,031	2,960	2,960	3,121	3,088	3,093	3,161	7,598
Харилцах, хадгаламж 5/															
Өрийн бичиг 4/	581	581	584	584	584	878	885	860	847	847	851	831	808	859	897
Зээл	735	852	949	1,135	1,305	1,404	1,366	1,813	1,822	1,901	1,912	1,976	1,982	1,994	6,333
Худалдааны зээл болон урьдчилгаа	31	230	247	280	339	358	332	357	291	212	358	282	302	307	368
Бусад өглөг 6/															
5 Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	8,357	9,033	9,830	10,029	10,341	10,665	10,674	10,825	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850	6,758
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	8,357	9,033	9,830	10,029	10,341	10,665	10,674	10,825	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850	6,758
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг															
Хамааралтай компани хоорондын өглөг															
Нийт гадаад өр	15,386	16,343	17,394	18,280	19,022	19,942	19,886	20,951	20,942	20,985	21,785	21,590	21,829	22,599	23,449